

БАТЛАВ
"БИДИСЕК" ХК

Б.ЛХАГВАДОРЖ
ТУЗ-ИЙН ДАРГА

2014 оны 08 сарын 12-ны өдөр

44

ЗАХ ЗЭЭЛИЙГ УРВУУЛАН АШИГЛАХААС СЭРГИЙЛЭХ ДОТООД ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмаар Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх "БиДиСек" ҮЦК-ийн мэргэжилтэн (уг нэр томъёог Санхүүгийн зохицуулах хорооны 2014.01.15-ны 07 тоот журмын 1.2.2-т тодорхойлсон) болон тус компанитай байгуулсан гэрээний хүрээнд үйлчлүүлж буй хөрөнгө оруулагч (цаашид харилцагч гэх)-ийн үнэт цаасны арилжаанд оролцоходоо зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. КОМПАНИЙН ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1 Компанид ажиллаж буй мэргэжилтэн нь доор дурьдсан арга хэлбэрээр үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахыг хориглоно:
- 2.1.1 Харилцагчийн ашиг сонирхлыг дээгүүр тавьж, албан үүргээ гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийг хувийн зорилгоор ашиглах.
 - 2.1.2 Үнэт цаасыг нийтэд худалдахаар санал болгох, үнэт цаасны арилжааны явцад харилцагчдад хуурамч мэдээлэл өгөх, төөрөгдүүлэх.
 - 2.1.3 Дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох, харилцагчдад хүргэх мэдээллийг нуун дарагдуулах, өгөхөөс татгалзах.
 - 2.1.4 Тухайн үнэт цаасны арилжаа идэвхтэй явагдаж байгаа мэтээр олон нийтийг төөрөгдүүлэх зорилгоор брокер, дилерийн болон нэгдмэл сонирхолтой бусад этгээдийн хооронд давхар гүйлгээ хийх.
 - 2.1.5 Харилцагчийн өгсөн буюу өгөх гэж буй нь баттай мэдэгдэж буй захиалга нь тухайн үнэт цаасны зах зээлийн үнэ ханшид нөлөөлөхүйц тохиолдолд тухайн захиалгыг хүлээн авч буй брокерийн компани

50

өөрийн дансаар тухайн үнэт цаасыг худалдах, худалдан авах, эсхүл гуравдагч этгээдийг худалдах, худалдан авахыг ятгах.

- 2.1.6 Үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд тараагдаагүй дотоод мэдээллийг олж авсан зохицуулалттай этгээд нь өөрийн дансаар тухайн үнэт цаасыг худалдах, худалдан авах, эсхүл гуравдагч этгээдийг худалдах, худалдан авахыг ятгах.
- 2.1.7 Харилцагчийн өмчлөлд байгаа үнэт цаасны тоо хэмжээ, түүнтэй холбогдох нийтэд тараагдаагүй мэдээллийг тараах, өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр сонирхогч этгээдэд уг үнэт цаасыг худалдан авахыг санал болгох.
- 2.1.8 Биелүүлэх зорилгогүй захиалгыг арилжааны програмд оруулах, түүнд засвар хийх, захиалга биелэгдэхээс өмнө цуцлах зэргээр тухайн үнэт цаасыг эрэлт, нийлүүлэлттэй мэт зохиомлоор харагдуулах үйлдэл хийх.
- 2.1.9 Арилжааны системийн мэдээллийн нууцлалыг алдагдуулах, урвуулан ашиглах.
- 2.1.10 Харилцагчийн тухайн үнэт цаасанд хамаарах захиалгыг бүрэн биелүүлсний дараа өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн захиалгыг биелүүлнэ.

Хоёр. КОМПАНИ БОЛОН ХАРИЛЦАГЧИЙН ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1 Компанид ажиллаж буй мэргэжилтэн болон харилцагчдад дараах үйл ажиллагааг хориглоно.
 - 3.1.1 Үнэт цаасны ханшийг бусадтай үгсэн хуйвалдаж зохиомлоор тогтоон барих, өсгөх, бууруулах үйлдэл хийх.
 - 3.1.2 Үнэт цаасны арилжааны явцад өмчлөгч нь өөрчлөгдөөгүй, нэгдмэл сонирхолтой этгээдийн хооронд үнэт цаасны үнэ, ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах зорилгоор гүйлгээ хийх.
 - 3.1.3 Арилжааны сүүлийн нэг цагийн туршид үнэт цаасны хаалтын ханшид нөлөөлөх зорилгоор худалдах, худалдан авах гүйлгээг хийх.

Гурав. БУСАД

- 4.1 ҮЦК-ийн ажилтан үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг зөрчих нөхцөлтэй харилцагчийн захиалгыг хүлээн авах, биелүүлэхээс татгалзах эрхтэй.
- 4.2 ҮЦК нь энэ журам болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн мэргэжилтэнд компанийн дотоод журам болон Дотоод хяналтын журамд заасан хариуцлага ногдуулна.
- 4.3 Харилцагч энэ журам болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөнийг илрүүлсэн тохиолдолд тухайн өдрөөс хойш ажлын 1 хоногийн дотор Хороонд мэдэгдэх;